

Санхүүгийн зохицуулах хорооны 2025  
оны .... дугаар сарын .... -ны өдрийн  
.... дугаар тогтоолын хавсралт

## **ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЖУРАМ**

### **НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх, ногдол ашиг хуваарилах, тайлагнах, түүнд хяналт тавихтай харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Энэ журмыг нээлттэй болон хаалттай хувьцаат компани үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

### **ХОЁР.НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ АЖИЛЛАГАА**

2.1.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэхийг шийдвэрлэх бөгөөд ногдол ашиг хуваарилах тохиолдолд Компанийн тухай хуулийн 47.1, 47.3-т тус тус заасан нөхцлийг хангасан байна.

2.2. Энэ журмын 2.1-д заасан төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрт Компанийн тухай хуулийн 46.1-д заасан мэдээллийг бүрэн тусгаж, компанийн хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.

2.2.Хувьцаат компани бэлэн мөнгө эсхүл компанийн хувьцаа болон бусад этгээдийн үнэт цаас хэлбэрээр хуваарилсан ногдол ашгийг зөвхөн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан ногдол ашиг тараалгах гэрээний үндсэн дээр дамжуулан хуваарилана.

2.3.Хувьцаат компани нь ногдол ашгийг татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилах бөгөөд санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрт заасан өдөр хуваарилана.

2.4.Давуу эрхийн хувьцаа болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь арилжааны банк дахь өөрийн харилцах болон хадгаламжийн дансанд ногдол ашгийг шилжүүлж авах хүсэлт гаргаж, холбогдох мэдээллийг өгсөн тохиолдолд ногдол ашгийг хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулж болно.

2.5.Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь нөлөө бүхий эсхүл жижиг хувьцаа эзэмшигч эсэхээс үл хамааран ногдол ашгийг хуваарилах өдөр нь адил байна.

### **ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ**

3.1.Хувьцаат компани нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай ногдол ашиг тараалгах гэрээ байгуулснаас хойш ажлын таван өдрийн дотор хувьцаа эзэмшигчид болон үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдэд ногдол ашгийн талаарх мэдээллийг хүргэж, Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 60 дугаар тогтоолын дөрөвдүгээр

хавсралтаар баталсан “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”-ын дагуу тус Хороонд мэдэгдэнэ.

3.2. Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээлэл ирсэн даруйд холбогдох мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд ажлын таван өдрийн дотор мэдээлнэ.

3.3. Хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан маягтын дагуу тус Хороонд ирүүлнэ.

~o0o~

**ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ  
АШИГ ХУВААРИЛАЛТЫН ТАЙЛАН**

Огноо:	...../...../..... (0000,cc,өө)
Дугаар:	.....

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРООНД**

<b>1.</b>	<b>Компанийн мэдээлэл</b>	
1.1.	Компанийн нэр:	
1.2.	Регистрийн дугаар:	
1.3.	Эзэмидэг тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн дугаар, эзэмисэн огноо, олгосон эрх бүхий байгууллага, хугацаа:	
1.4.	Компанийн нийт хувьцааны тоо, ширхэг:	
1.5.	Компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо:	
<b>2.</b>	<b>Ногдол ашгийн мэдээлэл</b>	
2.1.	Нийт ногдол ашиг:	
2.2.	Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ:	
2.3.	Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн компанийн эрх бүхий этгээдийн шийдвэрийн огноо, дугаар:	
2.4.	Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргасан өдөр:	
2.5.	Ногдол ашиг төлж эхэлсэн болон дууссан огноо:	
2.6.	Ногдол ашгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан хуваарилах гэрээний огноо, дугаар:	
2.7.	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан тараахаар байршуулсан огноо:	
2.8.	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар тараалгасан ногдол ашгийн мэдээлэл:	
2.9.	Олгогдоогүй ногдол ашгийг үлдэгдэл:	